

## САНАЛ АВАХ

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ , ДОТООД АУДИТЫН ДҮРЭМ /ТӨСӨЛ/

Дүрмийн төсөлд санал өгөхийг урьж байна.

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрэм нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ -ны хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын талаар баримталж буй бодлого, аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

#### **Хоёр. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааны бодлого, зарчим**

- 2.1.Хорооны дотоод үйл ажиллагааг шалгаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж, бие даасан хараат бус дүгнэлт өгч, Хорооны удирдлагад зөвлөх үйлчилгээ үзүүлэх нэгж болох Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрыг /цаашид ХШҮДАГ/ байгуулж, үйл ажиллагааг дэмжих нь Хорооны бодлогын салшгүй хэсэг байна.
- 2.2.ХШҮДАГ нь Хорооны даргын баталсан хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу болон тусгайлан өгсөн үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 2.3.ХШҮДАГ нь үйл ажиллагаагаа Хорооны даргад тайлагнана.
- 2.4. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжийн энэхүү дүрмийн дагуу гүйцэтгэнэ.
- 2.5. ХШҮДАГ нь үйл ажиллагаандаа Дотоод аудитын мэргэжлийн пратикийн олон улсын стандартад заасан шударга байх, бодитой байх, нууцыг хадгалах, ур чадвартай байх хараат бус байх зарчим баримтална.

#### **Гурав. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааны зорилго**

- 3.1 Хяналт шинжилгээ, дотоод аудитын зорилго нь Хорооны дотоод үйл ажиллагаа хууль тогтоомж, чиг үүргийн дагуу явуулж буй эсэхэд хяналт тавих, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд Хорооны удирдлага, нэгжид дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дөрөв. Хяналт шинжилгээ, дотоод аудитын үйл ажиллагаа

- 4.1.Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитыг дараах хүрээнд хийнэ:
  - 4.1.1. Хорооны үйл ажиллагааны стратеги, хуралдаанаар гарсан тогтоол, шийдвэр, өгсөн үүрэг даалгавар, жилийн ажлын төлөвлөгөө, бусад хөтөлбөр,

- тэдгээрийн хэрэгжилт, уялдаа холбоотой байдалд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- 4.1.2. Улсын Их Хурал, болон дээд газрын тушаал шийдвэр болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх;
  - 4.1.3. Ажлын албаны дотоод бүтцийн нэгжүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, газруудын үйл ажиллагааны харилцан уялдаатай байдал, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт хийх;
  - 4.1.4. Хорооны газруудын /нэгж/ үйл ажиллагаагааны төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
  - 4.1.5. Хорооны дарга, Ажлын албаны даргын тушаал, шийдвэр хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөж байгаа байдал, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж дүгнэлт гаргах ;
  - 4.1.6. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийх, төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;
  - 4.1.7. Хорооны улсын ерөнхий байцаагчийн шийдвэр болон улсын байцаагч нарын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх;
  - 4.1.8. Хорооны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг холбогдох газартай хамтран тогтоож, үнэлэлт дүгнэлт өгөх;
  - 4.1.9. Хорооны үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, зайлсхийх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, баримтлах бодлого боловсруулах;
  - 4.1.10. Хорооны үйл ажиллагааны эрсдэлийг хянан, тогтоох, сэргийлэх, тайлагнах талаар баримтлах заавар, журам гарын авлага боловсруулан хэрэгжилтэд нь хяналт тавих;
  - 4.1.11. Хяналт шалгалтын дүгнэлт, санал зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний талаар удирдлага болон холбогдох ажилтнуудад тайлагнах;
  - 4.1.12. **Хяналт** шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө болон авсан арга хэмжээний байдалд дүгнэлт өгөх, улмаар төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээ нь хангалттай эсэхийг шалгах;
  - 4.1.13. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилтэд аудит хийх, хэрэгжилтийг хангуулах;
  - 4.1.14. Хорооны анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтын байдал, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих, зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;
  - 4.1.15. Хорооны орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдалд үнэлэлт өгөх;
  - 4.1.16. Гадаад улс орон, олон улсын байгууллага, Засгийн газрын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих;
  - 4.1.17. Нягтлан бодох бүртгэлийн болон үйл ажиллагааны хяналт нь хангалттай эсэхийг шалгах;
  - 4.1.18. Дотоод хяналт шалгалтыг хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

- 4.1.19. Хороо нь нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж буй эсэхэд үнэлгээ хийж, эдгээрийг илүү хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах боломжийг тодорхойлон энэ талаар санал зөвлөмж өгөх;
- 4.1.20. Хорооны үйл ажиллагаатай болон чиг үүрэг, цалин хөлс, зэрэг дэв тогтоолт зэрэг ажилтнуудын гаргасан өргөдөл, гомдлын дагуу хяналт, шалгалт хийх.

#### 4.2. Дараах мэдээлэл, тайланг Хорооны даргад хүргүүлнэ:

- 4.2.1. хийсэн хяналт шинжилгээ, дотоод аудитын тайлан;
- 4.2.2. нэгжийн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан;
- 4.2.3. холбогдох үүрэг, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц;
- 4.2.4. хяналт шинжилгээ, дотоод аудитад хамрагдсан нэгжийн үйл ажиллагаанд анхаарах асуудал, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал;
- 4.2.5. шалгалтын явцад илэрсэн анхаарал татсан зөрчил дутагдал, түүний мөрөөр авсан арга хэмжээ, үр дүн.

Тав. Хяналт шинжилгээ, дотоод аудитын эрх, үүрэг

#### 5.1 Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын нэгж нь дараах эрхтэй:

- 5.1.1 Хорооны бүхий л үйл ажиллагаа, баримт бичиг, шийдвэр, хяналт шалгалтын тайлан, мэдээ судалгаа, санхүү, хөрөнгөнд хориг саадгүй нэвтрэх, ажилтнуудтай чөлөөтэй харьцах;
- 5.1.1. Хорооны дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааны хөтөлбөрийг удирдан чиглүүлэх, хэрэгжүүлэх;
- 5.1.2. газар, нэгжийн үйл ажиллагаатай танилцах, холбогдох албан хаагчтай уулзалт, ярилцлага хийх;
- 5.1.3. өмнө хийсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэх, хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалттай эсэхэд дүгнэлт өгөх;
- 5.1.4. хянан шалгагчид нь Улсын байцаагчийн эрхтэй байх;
- 5.1.5. хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

#### 5.2 Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын нэгж нь дараах үүрэгтэй:

- 5.2.1 хяналт шинжилгээ, дотоод аудитыг баталсан хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамжийн дагуу явуулах;
- 5.2.2 Хорооны даргын өгсөн чиглэл, үүргийн дагуу тусгайлсан хяналт шинжилгээ, аудит хийх;
- 5.2.3 үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт, дотоод аудиторын ёс зүйн дүрмийг чанд баримтлах;
- 5.2.4 хяналт шинжилгээ, дотоод аудитын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах;
- 5.2.5 дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын явцад танилцсан, олж авсан бүх баримт бичиг, мэдээллийг зөвхөн хяналт шалгалтын болон дотоод аудитын үйл ажиллагаанд ашиглах;
- 5.2.6 аливаа асуудалд шударга, бодит байдалд нийцүүлэн хандаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;
- 5.2.7 аудитын зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах;

- 5.2.8 хяналт шалгалтын танилцуулга, бусад баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэж, гарын үсэг зурах;
- 5.2.9 санхүүгийн хяналт шалгалтын болон аудитын материал, бичсэн танилцуулга, акт, тоо баримтын үндэслэл нотолгооны үнэн зөвийг хариуцах;
- 5.2.10 гаргасан зөвлөмж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, зохих журмын дагуу биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;
- 5.2.11 албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх;
- 5.2.12 аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар Хорооны удирдлагад мэдээлэх;
- 5.2.13 хууль тогтоомжд заасан бусад үүрэг.

Зургаа. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын төрөл, үе шат

- 6.1. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагааг дараах төрлөөр хийж гүйцэтгэнэ:
  - 6.1.1 Төлөвлөгөөт;
  - 6.1.2 Удирдлагаас өгсөн үүргийн дагуу буюу тусгайлсан чиглэлээр;
  - 6.1.3 Ажилтнудаас ирсэн хүсэлт, гомдлын дагуу.
- 6.2 Шалгалтыг үр дүнтэй, шуурхай явуулах үүднээс шалгалтын дараах үе шатыг баримтална:
  - 6.2.1 Шалгалтыг төлөвлөх;
  - 6.2.2 Шалгалтыг гүйцэтгэх;
  - 6.2.3 Шалгалтын үр дүнг тайлагнах;
  - 6.2.4 Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих.

Долоо. Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитад хийлгэж буй нэгжийн удирдлага, ажилтны үүрэг

- 7.1. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит явуулах үед шаардсан баримт бичиг, холбогдох судалгаа, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал асуулга явуулахад оролцоно.
- 7.2 Хяналт, шалгалт, дотоод аудитаас гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, шалгалтын тайланд тэмдэглэгдсэн зөрчлийг арилгах, арга хэмжээ авна.